

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2021 09 дугаар сарын 01

Дархан

БШУЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс хамтран зохион байгуулсан "Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэх арга зүй" сургалт 2021 оны 8-р сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтан, БСУГ-ын мэргэжилтнүүд 4 өдөр онлайн вебинар сургалтад болон лайв дамжуулалтаар бүрэн 100 хувь хамрагдсан.

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийн Элсэлтийн ерөнхий шалгалтад 08-р сарын 19-22-ны өдрүүдэд шалгалтын 3 байранд зохион байгуулагдсан. ЭЕШ-д 1121 шалгуулагч орхоос 1068 буюу 95.2% нь хамрагдсан. Үүнээс ковид өвчин туссаны улмаас 6 шалгуулагч ороогүй байсан.

Элсэлтийн ерөнхий шалгалтаар 6 төгсөгч үнэмлэхүй дээд оноо буюу 800 оноог авч эдгээр сурагчдыг бэлтгэсэн багшийн хамт болон 2 хичээлээр 700-аас дээш оноо, 1 хичээлээр 750-аас дээш оноо авсан нийт 20 сурагчдыг аймгийн Засаг дарга тэтгэлэг олгож шагнаж урамшууллаа.

Үндэсний хэмжээнд 2021–2022 оны хичээлийн жилд элсэлтийг цахимаар бүртгэж эцэг эх, асран хамгаалагчид [www.parent.edu.mn](http://www.parent.edu.mn) гэсэн хаягаар тухайн сургуульд бүртгүүлсэн хүүхдийн бүртгэлийг баталгаажуулах журмаар явагдлаа.

Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн элсэлт 08 дугаар сарын 16–30-ны өдрүүдэд явагдаж дууслаа.

Аймгийн хэмжээнд нийт 2415 сурагч цахимаар бүртгүүлэх байснаас 57 хувь буюу 1385 сурагч, уламжлалтаар 835 сурагч нийт 2211 сурагч 72 бүлэгт бүртгүүлэн хичээл сургалтын үйл ажиллагаа эхэлж байна.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлт зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх МОН-323 төслийн хүрээнд химийн сургалтанд ашиглах урвалж бодисын багцыг аймаг, дүүргийн боловсролын газруудаар дамжуулан 100 сургуульд лаборатори нийлүүлсэн байна. Дархан-Уул аймгийн Оюуны-Ирээдүй, Од цогцолбор, 15,16,18 сургуулийн химийн кабинетид нийтдээ 14.900.000 төгрөгийн бодис өгсөн байна.

Хичээл сургууль эхлэхтэй холбоотой эрүүл мэндийн сайдын А/145-р тушаалын хэрэгжилтийг хангаж БСУГ-ын гаргасан хуваарийн дагуу СӨБ төрийн өмч ба төрийн бус өмчийн 41 цэцэрлэгийн 1023 албан хаагч, ЕБ-ын төрийн өмч ба төрийн бус өмчийн 21 сургуулийн бага ангийн багш, тогооч, бага ангид хичээл ордог мэргэжлийн 788 багш, нийт 1811 албан хаагч урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.

Ковид-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтын 3-р тунд БСУГ-ын албан хаагч, ЕБС, СӨБ-ын 1432 багш, удирдах ажилтан хамрагдахаас 846 албан хаагч хамрагдсан нь 59% байна.

СӨББ-уудын хүний нөөцийн судалгааг нэгтгэж СӨББ-уудад шинээр гарч буй ажлын байрны сонгон шалгаруулалтыг нээлттэйгээр зарлаж бүртгэгдсэн иргэдэд мэдээлэл өгч ажилласан. Дархан сумын хэмжээнд 1, 3, 5, 12, 13, 15, 17, 24, 27, 29 дүгээр цэцэрлэгүүд сонгон шалгаруулалтыг нээлттэйгээр зарлаж үндсэн болон түр **23 орон тоон** дээр бүлгийн багш, дуу хөгжмийн багш, нярав, тогооч, туслах багш, эмч шалгаруулж авсан байна.

Аймгийн хэмжээнд нийт цэцэрлэгүүдийн байршил, хамран сургах харъяа тойргийн байруудыг гинэчлэн тогтоож, шинээр элсэлт авах бүлэг хүүхдийн тооны хамтаар нээлттэйгээр иргэд олон нийтэд мэдээллэж зарыг хүргэн 2021.08.19-20-ны өдрүүдэд БСУГ-аас өгсөн чиглэлийн дагуу элсэлтийн журмыг цэцэрлэг бүр боловсруулж эрхлэгчийн тушаалаар ажлын хэсэг гаргаж элсэлтийг зохион байгуулсан. 08 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд цэцэрлэгийн хүүхдийн элсэлтийн бүртгэлийг хийж 4, 5 насны 3863 хүүхдийг бүртгэсэн.

БМДИ-ээс зохион байгуулсан “24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгийн бүлгийн багшийг чадавхжуулах арга зүйн зөвлөмж” вебинар сургалтад 10, 16, Хэрэмхэн цэцэрлэгүүдийн 16 багш, арга зүйчийг хамруулсан.

Цэцэрлэгийн хүүхдийн эрүүл мэндийн шинжилгээг 5 лабораторитой гэрээ байгуулж хийлгэсэн бөгөөд энэ хугацаанд нийт 1209 хүүхдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийснээс 86 хүүхдэд цагаан хорхойн эмгэг илэрсэн. /Үзлэгт хамрагдсан хувь 31%/

Өргөө багт баригдаж байгаа 100 хүүхдийн цэцэрлэг барилгын ажил 98%-тай явагдаж байна.

Насан туршийн боловсролд “Ажил мэргэжлийн чиг баримжаа мэдээллийн төв” байгуулах зорилгоор БШУЯ-аас 652,0 мянган төгрөгийн компьютер техник хэрэгслийн хөрөнгө оруулалт нийлүүлэгдсэн

Дархан сумын 1, 15, Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулиудад хийгдэж байгаа БШУ-ны сайдын багцын засвар ажлууд 95-99%-тай явж байна.

ЕБС-иудад 1-7-р ангийн 37 төрлийн 13621 ширхэг 29,414,755 төгрөгийн сурах бичиг ирсэн байна

Дархан-Уул аймагт эмчлэн болон ажиглан тусгаарлах нийт 7-12 байр бэлтгэж бэлтгэл бэлэн байдлыг хангуулж 1500 гаруй иргэдэд үйлчилсэн байна.

Ковид-19 коронавирусын халдварын тохиолдол ихсэж эмнэлгийн ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан ЭМС-ын гаргасан тушаал шийдвэрийн хүрээнд Коронавируст халдварын хөнгөн хэлбэрээр өвчилсөн иргэдийг эрэмбэлэн ангилж гэрээр эмчлэж, хянаж байна.

Дархан-Уул аймгийн ковидын тархалт буурахгүй байгаатай холбоотой хувийн хэвшлийн Саран клиник нэгдсэн эмнэлэг, Цанид, Эрхэм, Буянтай, Дархан үйлс зэрэг 5 эмнэлгүүдийг татан оролцуулж, шинээр 300 гаруй ор дэлгэж үйл ажиллагааг эхлүүлж иргэдийг эмчлэн тусгаарах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.

ЭМБуудад өгсөн хамгаалах хэрэгсэл ПГУ оношлуур, түргэвчилсэн оношлуур эмнэлгийн хэрэгсэл, эм зарлагуудыг [burtgel.mohs.mn](http://burtgel.mohs.mn) цахим программд шивж тогтмол оруулж байна.

ЭМГ Шуурхай штапын 24 цагийн хариуцлагатай жижүүрүүд хуваарийн дагуу ажиллаж, ЭМБуудаас НЭ, Өрх, 3 Сумын ЭМТөвүүдээс ковидын үед авч хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээ тусгаарлах үйл ажиллагаа, ковидын шинжилгээ зэрэг цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлийг авч нэгтгэн ЭМЯ, ЭМХТөв, Аймгийн ОБГ, АЗДТГ, Цагдаа, Тагнуул, МХГ гэх мэт холбогдох газруудад 2 цаг тутам мэдээлж ажиллаж байна. Шуурхай штабын 70374157, 703710 утсанд ирсэн нийт 1674 дуудлаганд хариу өгч ажилласан байна.

2020 оны 11 сараас 2021 оны 09 сарыг 02-ныг хүртлэх Нэгдсэн эмнэлэгт, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт:

- Түргэвчилсэн шинжилгээ–69659 /Нийт сул эерэг 2434/
- Нийт PCR шинжилгээ–78879 /Нийт эерэг 7551/
- Үүнээс: Цэгүүдээр PCR-ийн шинжилгээ – 33573 /эерэг 4/
- Нэгдсэн эмнэлэгт PCR-ийн шинжилгээ – 45306 /эерэг 7547/

Нийт 7530 тохиолдол /3 УБ, 1 зөөв, 1 бат, 4 сэл, 12 сэлэнгэ/ батлагдсан байна.

Мөн түр тусгаарлах байранд ажиллаж байгаа Эрүүл мэндийн ажилчдын халдварын сэргийлэлтэд хяналт тавих, аргазүйн зөвлөмж өгөх, эмнэлгийн мэргэжилтнүүдийн халдвар хамгааллын дэглэмийг сайжруулах зорилгоор Дотоод хяналт хийсэн.10 төрлийн зөвлөмж хүргүүлж түр тусгаарлах байрны нийт 1800 м2 талбайд голомтын халдваргүйтгэл хийсэн.

Ковид-19 өвчний учир нас барсан иргэний ар гэрийн хүсэлтээр ажлын хэсэг хуралдаж, Улаанбаатар Буян ХХК-д чандарлуулах үйл ажиллагааг зохион байгуулав.

Ковидын дархлаажуулалтын үйл ажиллагааг дэмжих эрчимжүүлэх зорилгоор НЭМТ-ийн шууд ярилцага цахимаар тогтмол зохион байгуулж байна.

2021.08.31 ны өдрөөс эхлэн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор коронавирүсийн халдварын эсрэг вакцины 3 дугаар тунгаар дархлаажуулах үйл ажиллагааг Дархан-Уул аймагт зохион байгуулж байна. Энэ үйл ажиллагааны хүрээнд эхний ээлжинд Дархан-Уул аймгийн Эрүүл мэнд, Сургууль, цэцэрлэг буюу боловсролын байгууллага Цагдаа, онцгой байдлын газрын алба хаагчид болон 55 аас дээш насны ахмадууд, архаг хууч суурь өвчтэй зорилтот бүлгийн иргэдийг коронавирүсийн халдварын эсрэг вакцины 3 дугаар тунд сайн дурын үндсэн дээр хамруулж байна

Нийт үзлэг-8261 үүнээс урьдчилан сэргийлэх 2879 / 23.9% / үзлэг байна.

- Ор хоногийн гүйцэтгэл -12124 байна. эмчлэгдсэн өвчтөн-1641
- эмнэлгийн нас баралт 8-тох үүнээс нярайн нас баралт- 1
- Яаралтай дуудлагын утсанд нийт – 8735 дуудлага хүлээн авсан байна.
- Нийт төрөлт-114
- гэрийн төрөлтийн тохиолдол -0
- амьгүй төрөлт-0

Нийт хагалгаа 251 хийгдсэн.

“Гэр бүлийн хөгжлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-т хамрагдсан 270 өрхөд дахин үнэлгээ хийж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон шаардлагатай үйлчилгээг үзүүлэх зорилгоор 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулан 68 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж , хамгааллын хариу үйлчилгээнд хамрууллаа.

Түр хамгаалах байранд насанд хүрэгч 1, хүүхэд 1, нийт 2 хүний аюулгүй байдлыг ханган сэтгэл зүйн үйлчилгээ 2, хууль эрх зүйн үйлчилгээ 2, эрүүл мэндийн үйлчилгээ 1, хүүхэд хамгааллын үйлчилгээ 1, боловсролын үйлчилгээ 48 цаг, нөхөн сэргээх чадавхжуулах үйлчилгээ 1 удаа тус тус үзүүллээ.

Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан сэтгэл зүйн болон сэтгэл заслын үйлчилгээг 20 иргэнд зөвлөгөө өгч, 1 иргэнийг эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучиллаа.

Шүүхчийн захирамжийн дагуу 4 гэр бүлд шинжээчийн багаар ажиллан дүгнэлт гаргалаа.

Засгийн газрын 2017 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-д Монгол улсын Засгийн газрын “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 06

дугаар сарын 01-ний өдрийн 159 дүгээр тогтоолоор нэмэлтээр оруулсан өөрчлөлтийн дагуу хүүхдийн мөнгөн тэтгэмж олголтыг зогсоох асуудлаар 14 иргэнээс өргөдөл хүлээн авч, 4 өргөдөлд Хүүхдийн эрхийн байцаагчийн дүгнэлтийг гаргасан.

Хүүхдийн тусламжийн 108 утаснаас ирүүлсэн 22 дуудлага, мэдээллийг хүлээн авч, 17 дуудлагыг шийдвэрлэж, 5 дуудлага шийдвэрлэх шатандаа явагдаж байна.

Хүүхэд үрчлэх хүсэлт гаргасан 9 иргэний материалыг хүлээн авч нөхцөл байдлын үнэлгээ хийж дүгнэлтийг Дархан сумын ЗДТГазарт хүргүүллээ.

Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд шинжээчдийн 18 гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, 9 дүгнэлт гаргаж хүргүүлсэн.

Хүүхэд хөгжлийн ордон мэргэжлийн байгууллагын өгсөн заавар зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлж халдвар хамгааллын дэглэмийг баримтлан 6 дугуйланд 49 хүүхэд, номын сангаар 37 хүүхэд, шинээр карт нээлгэсэн 9 хүүхэд, уншлагад гарсан ном 96, 406 хүнд үйлчилгээ үзүүлсэн.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх үүднээс бүжгийн спорт сонирхогч хүүхэд багачуудын дунд “Уухай” бүжгийн цахим уралдааныг зарласан.

Сумдын залуучуудын хөгжлийн зөвлөлийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулж 17 гишүүн хамруулж, улсын төсвөөс 1.332.000 төгрөгийн санхүүжилт хийгдсэн.

Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойг угтан “Хорт зуршилгүй залуу 100” сэдэвт аяны хүрээнд хорт зуршил, өвчилөлөөс урьдчилан сэргийлэх, иргэн бүр эрүүл дадал, хэвшилтэй байхыг уриалан хүүхдийн тоглоомын талбайд согтууруулах ундаа болон тамхи татаж, хог хаягдал хаяж бохирдуулж буй иргэдэд санамж өгөх, хариуцлагатай, хорт зуршилгүй залуу байх нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 100 залуу хамрагдаж удсын төвсөөс 58.600 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн БОАЖГ, “Хар ус гол”, ШИНОБУ жим, “Дарханы нөхөрсөг залуус” сошиал идэвхитэй цахим хуудсын гишүүд, өсвөр үе залуучуудын оролцооны 3 клуб, “Элит хөгжил” ХХК-тай хамтран “Хараа голоо цэвэрлэцгээ” сайн дурын ажилд залуучуудыг уриалж аялал зугаалгын бүс болсон Хараа голын эргэн тойронг цэвэрлэх ажлыг зохион байгуулж нийт 120 залуучууд оролцож 300 шуудай хог түүж НААҮГ-т ачуулж Хараа голын орчмыг цэвэрлэлээ.

Аймгийн ОБГазартай хамтран Монгол Улсын Шадар Сайдын баталсан 2021 оны 8 дугаар сарын 09-ны өдрийн “Үер, уснаас үрсээ хамгаалъя” аяны удирдамжийн хүрээнд Хараа голын орчмоор хяналт тавьж иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч, үер уснаас урьдчилан сэргийлэх 270 ш гарын авлага материалыг хэвлүүлэн, түгээж, улсын төсвөөс 243000 төгрөгийн санхүүжилт хийсэн.

Гүүднэйборс Олон Улсын Байгууллагатай хамтран өсвөр, үе, хүүхэд багачуудын дунд “Дүрэмт хувцасаа бэлэглэе” аяныг 5 өдрийн турш өрнүүлж 144 дүрэм хувцас цуглуулж зорилтот бүлгийн хүүхдүүдэд хандивлав.

Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийн 1 дүгээр шатанд нийт 274 залуучууд бүртгүүлж, 2 дахь шатны шалгаруулалтад 176 залуучууд оролцсноос 78 залуучууд шалгарсан.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн үндэсний чуулган уулзалт цахимаар зохион байгуулж аймгийн залуучуудын төлөөлөл 35 залуучууд оролцлоо.

Өсвөр үе, залуучуудын оюуны хөгжилд хөрөнгө оруулалт хийх зорилгоор “Хөгжилд бэлэн үү” хувь хүний хөгжлийн академик хөтөлбөрийн хүрээнд 9 сургагч багшийн бүрэлдэхүүнтэйгээр зорилтот бүлгийн 20 залуу, өсвөр үе ахлах ангийн 20 залуу, сайн дураар бүртгүүлсэн 60 залуу нийт 100-н залуучуудад 5 өдрийн сургалтыг зохион байгуулж улсын төсвөөс 1.619.250 төгрөгийн санхүүжилт хийлээ.

**Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “ОРОЛЦОО” төсөл хэрэгжиж эхэллээ.** МУ-ын ЗГ-аас хэрэгжүүлж буй 5000 залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 18-34 насны ажил хөдөлмөр эрхлээгүй, оюутан сурагч биш залуучуудыг бүртгэх, ярилцлагад оруулах, эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг 08-р сарын 16-аас 30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 176 залуу хөтөлбөрийн ярилцлагад тэнцэж төсөл хөтөлбөрт хамрагдах шалгуур хангасан бол эрүүл мэндийн үзлэг, ар гэрийн гачигдал бусад шалтгаанаар 34 залуу төсөлд хамрагдах боломжгүй болсноор 142 залуу хөтөлбөрт хамрагдахаар болж 09 дүгээр сарын 02-ны өдөр Улаанбаатар хотыг зорихоор болоод байна. 142 залуу Улаанбаатар хотод 14 хоногийн вакумжуулсан сургалтад хамрагдсаны дараа орон нутагтаа томоохон үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллагуудад ажлын байрны дадлага хийж улмаар ажилд зуучлагдах бөгөөд нийт сургалтад хамрагдсан залуучуудын 70 болон түүнээс дээш хувийг байнгын ажлын байранд зуучлах, ажлын байртай болгох зорилтыг тавин ажиллаж байна.

**Зорилтот бүлгийн, ажилгүй иргэд ургац хураалтын ажилд сайн дураар оролцох оролцоог ханган ажиллаж байна.** МУ-ын ЗГ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санаачилгаар зорилтот бүлгийн, ажил хөдөлмөр эрхлээгүй тэр дундаа хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхийн гишүү-иргэн, хөдөлмөрийн насны иргэдийг 2021 оны ургац хураалтын ажилд хамруулах ажлыг 08-р сарын 20-ны өдрөөс эхлэн зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд 13 аж ахуй нэгж, иргэдийн захиалгаар давхардсан тоогоор 319 иргэн ургац хураалтын ажилд сайн дураараа хамрагдсан бөгөөд өдрийн ажлын хөлсийг ажил олгогчтой хийсэн гэрээнд тусган 30,0-60,0 төгрөгөөр цалинжуулан ажиллуулах, ажил олгогч болон ажилгүй иргэдийг холбон зуучлах хэлбэрээр ургац хураалтын ажилд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

**Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 61 иргэнийг хамрууллаа.** Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний хүрээнд “Монгол хүн-Хөгжлийн тулгуур” ТББ, Дархан-Уул аймгийн “Хөдөлмөрийн бирж”-тэй хамран Дархан сумын 1, 2, 3, 15 дугаар багийн Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхийн гишүүн-иргэн, хөдөлмөрийн насны 61 иргэнийг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрууллаа.

**265 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучиллаа.** 08 дугаар сард давхардсан тоогоор 65 аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн 195 байнгын ажлын байрны, 8 иргэн, аж хуй нэгж, байгууллагаас ирүүлсэн 180 түр ажлын байрны захиалгыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн салбараар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж байнгын ажлын байранд 61 иргэн, түр ажлын байранд 204 иргэн, нийт 265 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан.

**Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд 12 иргэнийг хамрууллаа.** Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний гэрийн асрамж халамжийн үйлчилгээ

үзүүлэхээр Дархан-Уул аймгийн Улаан загалмайн хороотой хамтран ажилах гэрээ байгуулж байнгын асаргаанд хэвтэрт байдаг 11 ахмад настан, 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулж 3,360,0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон.

**Ахмад настны Өдрийн үйлчилгээнд 100 иргэнийг хамрууллаа.** Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан ахмад настны “Өдрийн үйлчилгээ”-г “Мөнхтийн таг” ТББ-тай хамтран зохион байгуулж Дархан сумын 100 ахмад настанг үйлчилгээнд хамруулж 9,0 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо.

**Сэргээн засах үйлчилгээнд 36 иргэнийг хамрууллаа.** Халамжийн сэргээн засах үйлчилгээг “Би энд Зет”, “Энхийн соёл” байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж 34 ахмад настан, 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулж 9,129,0 мянган сая төгрөгийн санхүүжилт олголоо.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн А/96 тоот тушаалаар албан бус эдийн засагт ажиллаж буй иргэд-сайн дурын даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилах, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ ач холбогдлын талаар мэдээлэх, таниулах зорилгоор “Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх” аяныг 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд зохион байгуулж байна. Уг аяны хүрээнд 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/25 дугаар хэлтсийн даргын тушаал гарган төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Хэлтсийн байцаагч нар төлөвлөгөө хуваарийн дагуу 8 хэсэгт хуваагдан томоохон зах худалдааны төв болон иргэдтэй “Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх” зорилгоор уулзан аяныг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Мөн сайн дурын даатгал төлөгчдөд мэдээ мэдээлэл хүргэх зорилгоор 3 байцаагч Шууд Live-аар иргэд даатгуулагчдын сонирхсон асуултанд хариулт хүргэн ажилласан.

## **ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**